



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Манлайллыг үзүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх жил”

2025 он

АГУУЛГА

Нэг. Ерөнхий тойм

Хоёр. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа

- 2.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд;
- 2.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн;
- 2.3 Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд өгсөн санал;
- 2.4 Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээ;
- 2.5 Хүний нөөцийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- 2.6 Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр;
- 2.7 Сургалтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- 2.8 Санхүү төлөвлөлт, аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- 2.9 Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол, шийдвэрлэлт;
- 2.10 Мэдээллийн технологийн чиглэлээр гүйцэтгэсэн арга хэмжээ;
- 2.11 Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр;

Гурав. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

- 3.1 Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр;
- 3.2 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр;
- 3.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр;
- 3.4 Зөөврийн тоног төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байдал
- 3.5 Бичиг баримтжуулах ажлын хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээ;
- 3.6 Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд гүйцэтгэсэн арга хэмжээ;
- 3.7 Улсын бүртгэлийн архивын чиглэлээр гүйцэтгэсэн арга хэмжээ;

Дөрөв. Бүртгэл хяналтын чиглэлээр

- 4.1 Хяналт шалгалтын чиглэлээр;

Тав.Нөхөн сонгууль зохион байгуулах чиглэлээр гүйцэтгэсэн арга хэмжээ

- 5.1 Нөхөн сонгууль зохион байгуулах чиглэлээр гүйцэтгэсэн арга хэмжээ;

Зургаа. Бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр;

- 6.1 Бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр хийсэн ажил

Долоо. Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан ажил

- 7.1 Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан ажил

Найм. Улсын бүртгэлийн хэлтсээс шинээр санаачилан хэрэгжүүлсэн арга хэмжээ;

- 8.1 Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан ажил

Ес. Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойн арга хэмжээ;

- 9.1.Улсын бүртгэлийн хэлтсээс 85 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан

ажил

Арав. Дүгнэлт.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ

Улсын бүртгэлийн хэлтэс нь Дорноговь аймгийн хэмжээнд төрөөс хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг баримтлан Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2025 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, бүртгэлийн үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангах, хуульд заасан улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх үндсэн чиг үүргийн дагуу Захиргаа удирдлагын хэлтэс /6/, Иргэний улсын бүртгэлийн тасаг /16/, Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг /4/ гэрээт ажилтан /2/ нийт 28 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд 2025 онд орон нутгийн иргэдэд улсын бүртгэлийн үйл ажиллагааг хүндрэлгүй, чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх зорилтыг дэвшүүлж “Манлайллыг үзүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх” жил болгон зарласан.

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 39531 иргэн, хуулийн этгээдэд үзүүлээд байна.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Тус хэлтэс нь “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөр, Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил” аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2025 оныг “Аялал жуулчлалыг дэмжих” жил болгон зарласан аймгийн Засаг даргын 2025 оны А/01 дүгээр захирамж, “Цахим Дорноговь” хөтөлбөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах зорилт арга хэмжээг үйл ажиллагаагаандаа төлөвлөн ажиллаж байна.

2.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн:

Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүний нөөцтэй холбоотой тушаал-15, чиглэл 13, зөвлөмж 9, хугацаатай үүрэг даалгавар-4, хяналтын улсын байцаагчийн албан шаардлага-1, албан даалгавар-5, Аймгийн Засаг даргын албан даалгавар-3, чиглэл-8, зөвлөмж-1 тус тус ирснийг хяналтанд авч, хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.

2.3 Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгсөн тухай:

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд гэрлэлт дуусгавар болсны бүртгэл, эцэг эхийн овог өөрийн нэр солих бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам, хуулийн этгээд, түүний салбар төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам, тамга тэмдэг хийлгэх, үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, “Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2025 оны төлөвлөгөө”-ний төсөлд, мөн аймгийн Засаг даргын Тамгын газраас Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтад оруулах санал, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний улсын бүртгэлийн тухай хууль, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудад хяналтын байцаагчийн чиг үүрэгтэй холбоотой санал, “Сумдад хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах төслийн хүрээнд хийгдэж байгаа эд хөрөнгийн

эрхийн улсын бүртгэлийн ажлын даалгаварт тусгах саналыг холбогдох газруудад тус тус цаг тухайд хүргүүлэн ажилласан.

2.4 Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр гүйцэтгэсэн арга хэмжээ:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуралдаанд тухай бүр оролцож хуралдаанаас өгсөн 3 үүргийн биелэлт, УБЕГ-ын даргын зөвлөлийн хуралдаанаас өгсөн 3 үүрэг даалгаварыг тус тус гүйцэтгэж биелэлтийг тухай бүр гаргаж холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлсэн.

Мөн Аймгийн Засаг дарга болон агентлагийн дарга нарын шуурхай хуралдаанд 16 удаа оролцож үүрэг даалгаварын биелэлтийг 100 хувь ханган хүргүүлсэн.

Өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд дотоод хуралдааныг 14 удаа зохион байгуулж, албан хаагчдад нийт 27 үүрэг даалгавар өгч, биелэлтийг ханган ажиллаж байна.

2.5. Хүний нөөцийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/67 дугаар тушаал батлагдсантай холбогдуулан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй оролцогчдыг талаар тайлбар, санал авах боломжоор хангах тухай захиргааны шийдвэрийн талаар Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад сонсох ажиллагааг хийсэн.

Мөн Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энх-Эрдэнэ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2025 оны “Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/45 дугаар тушаал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн “Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/157 дугаар тушаал, мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эрхзүйн хэлтсээс 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 1-2-/10647 дугаартай албан бичигтэй танилцаад албан хаагч нарт Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4, Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонсох ажиллагааг явуулах асуудлаар урьдчилан мэдэгдэж сонсох ажиллагааг 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр гүйцэтгэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/157 тушаалаар тус хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд

хязгаарыг 29, мөн 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн Б/407 дугаар тушаалаар гэрээт ажилтны 2 орон тоо, нийт 31 орон тоотойгоор баталсан.

Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн баталсантай холбогдуулан тус хэлтсийн албан хаагчдыг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс чөлөөлж, 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр тус хэлтсийн албан хаагчдыг томилсон.

Тайлант хугацаанд тус хэлтэс нь төрийн захиргааны 23, төрийн үйлчилгээний 4, гэрээт 1 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулсан. Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага хангасан албан хаагчид ажиллаж байгаа бөгөөд шаардлага хангаагүй зөрчилтэй томилгоо байхгүй байна.

Мөн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээнд ажилладаг нийт 27 албан хаагч ажиллаж байгаагаас 1-5 жил хүртэл ажиллаж байгаа 6 албан хаагч, 6-аас дээш жил ажилласан 21 албан хаагч тус тус тогтвор суурьшилтай ажилласан байна.

ХАСХОМ-ийн 2024 оны тайланг 28 төрийн захиргааны албан хаагч хуулийн хугацаанд буюу 2025 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн гаргуулж баталгаажуулсан.

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн мэдээллийн санд 27 албан хаагчдын мэдээллийг тухай бүр шинэчилж, мэдээлэл өөрчлөгдсөн үед тухай бүр бүртгэлийг хөтлөн нууцлал, хамгаалалтыг баримтлан ажилласан.

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд дутуу бүртгэгдсэн эзэмшсэн мэргэжил 19, боловсролын түвшин-1 алдаатай бүртгэгдсэн алдааг засварлаж “Төрийн албан хаагчийн портал” системд албан хаагч тус бүрийг баталгаажуулан ажилласан.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 15 тушаалыг хүлээн авч, холбогдох албан хаагч нарт танилцуулан хэрэгжилтэнд, хяналт тавин ажиллаж байна. Хуульд заасан бусад төрлөөр буюу Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт зөрчсөн, ёс зүйн зөвлөлийн шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй байна.

Тус онд хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой дараах 6 тушаал гарсан байна. Үүнд:

- Ээлжийн амралтын хуваарь батлах тухай-1
- Цалин хөлс, ур чадварын нэмэгдэл олгохтой холбоотой-9,
- Ажлаас чөлөөлж, томилох тухай тушаал-3

Тайлант хугацаанд 14 албан хаагчийг шагнаж урамшуулсан ба шагналын төрлөөр авч үзвэл: Тус хэлтсийн 85 жилийн ойг угтаж бүртгэлийн салбарт олон жил үр бүтээл, идэвхи зүтгэлтэй ажиллаж, ажлаараа тэргүүлсэн албан хаагч нарыг тодруулж “Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан” цол, тэмдгээр-2, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-3, УБЕГ-ын “Хүндэт жуух бичиг”-5,

аймгийн Засаг даргын “Жуух бичиг” шагналаар -1, аймгийн Засаг даргын “Өргөмжлөл”-өөр 1, Сайншанд сумын ИТХ-ын “Өргөмжлөл”-өөр-2, Хууль хяналтын харилцагч байгууллагын “Талархлын бичиг”-ээр 2 албан хаагчийг тус тус шагнасан.

Төрийн захиргааны албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газар дахь салбар зөвлөлд санал хүргүүлж Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны Б/248 дугаар тушаалаар зэрэг дэвийг 9 албан хаагчид шинээр болон ахиулан олгосон.

2.6 Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд хийсэн ажил:

“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

- 2025 оны 04 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд улсын бүртгэгч нарыг мэргэшүүлэх нэгдсэн сургалт зохион байгуулж сургалтын зардалд 300,000 төгрөг зарцуулсан.

- Удирдлагын академийн дунд хугацааны сургалтад Замын-Үүд сумын улсын бүртгэгч, мөн Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдах тухай 2 албан хаагчийн хүсэлтийг Эрхзүйн сургалтын хэлтэст хүргүүлсэн.

- УБЕГ-ын даргын 2025 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/172 дугаар тушаалын дагуу төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, дадлагажуулах сургалтанд хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ хамрагдсан.

- УБЕГ-ын даргын Б/458 дугаар тушаалаар нэг албан хаагчид шинээр зэрэг дэв олгосон 1 бол зэрэг дэвийг 8 албан хаагчид ахиулан олгосон.

- УБЕГ-ын даргын шийдвэрээр иж бүрэн компьютер-1, зөөврийн 3 компьютер, принтрийн асуудлыг шийдвэрлэсэн.

- Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан "Хамгийн чухал нь" зорилтот арга хэмжээний хэрэгжилтийг хангаж Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2025 оны 04 дүгээр сарын 09,10-нд сумын улсын бүртгэгч нарыг, 04 дүгээр сарын 26-нд хэлтсийн албан хаагчид, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг баг бүрэлдэхүүн тус аймагт ирж 2025 оны 05 дугаар сарын 22-нд эрүүл мэндийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд албан хаагчдыг бүрэн хамруулсан.

- Хэлтсийн албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон сар бүр унаа, хоолны мөнгө, орон нутгийн нэмэгдэл, төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг үндсэн цалин дээр нэмж олгосон.

- Улсын бүртгэлийн байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.15.2-д заасны улсын бүртгэгч нас барахад ар гэрт нь 1 удаагийн буцалтгүй мөнгөн тусламж, хэлтсийн албан хаагчдын хуримтлалын сангаас ар гэрт гачигдал тохиолдсон, 6 албан хаагчийн гэр бүлд нь нийт 4,380,000 төгрөгийн тусламж үзүүлсэн байна.

- Сайншанд хотод үйл ажиллагаа явуулдаг барилгын компаниудын удирдлагуудтай уулзалт хийж Энержи парагон ХХК-ийн 2025 оны 3 дугаар улиралд ашиглалтанд орсон орон сууцнаас 1 албан хаагчид хөнгөлөлттэй үнээр, мөн Гантулга трейд ХХК-ийн Мандах наран хорооллын төрийн албан хаагчийн түрээсийн орон сууцанд 1 албан хаагчийг тус тус хамруулж нийгмийн баталгааг ханган ажилласан.

2.7 Сургалтын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил:

УБЕГ болон бусад газраас хийсэн онлайн болон танхимын дараах сургалтуудад хамрагдсан байна. Үүнд:

1.2025 оны 1 дүгээр сарын 13-нд Татварын газраас Хяналт шалгалтын тасгийн Татварын улсан байцаагч Э.Мөнхгэрэл “Хувь хүний орлого албан татварын хөнгөлөлт чөлөөлөлт” сэдэвт сургалт.

2. Прокурорын газраас зохион байгуулсан танхимын “Зөрчлийн нэгдсэн сангийн програмын шинэчлэлт” сургалтанд 2025 оны 01 дүгээр сарын 24-нд Э.Уранбилэг хамрагдсан.

3.УБЕГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 31 өдөр зохион байгуулсан цахим сургалтанд ERP.E-mongolia.mn системийн Мэдээлийн тенхологийн ажилтан П.Азжаргал, бичиг хэргийн эрхлэгч Н.Цэндмаа хамрагдсан

4.УБЕГ-аас 2025 оны 02 дугаар сарын 11 өдөр зохион байгуулсан Авилгатай тэмцэх газрын комиссар Ц.Сэлэнгэ “Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт цахим сургалтанд хэлтсийн албан хаагчид

5.УБЕГ-аас 2025 оны 02 дугаар сарын 11 өдөр зохион байгуулсан Иргэний 8 төрөл болон гадаад паспорт дээр анхаарах асуудал сэдэвт цахим сургалт Хяналтын ахлах улсын байцаагч

6.Аймгийн Шүүхийн тамгын газраас 2025 оны 03 сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Эвлэрүүлэн зуучлах” сэдэвт танхимын сургалтанд хэлтсийн албан хаагчид

7.УБЕГ-т 2025 оны 03 сарын 31-04 сарын 01-ний хооронд “Удирдах ажилтны зөвөлгөөн” хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ, Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Г.Батсайхан нар оролцсон

8.АЗДТГ-т 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр “Удирдах ажилтны зөвөлгөөн”-д Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Б.Баттуяа хамрагдсан.

9.УБЕГ-ын ЭХЭУБГ болон Монголын нотариатчдын танхимтай хамтарсан цахим сургалтанд “Нотариатчийн цахим системд зуучлалын модуль нэвтрүүлэх” 2025 оны 04 дүгээр сарын -05-нд ЭХЭУБТасгийн болон сумын улсын бүртгэгч нар хамрагдсан.

10.УБЕГ-ын ИБГаас 2025 оны 4 дүгээр сарын 15 өдөр “Мэдээллийн санд эрх нээх, хаах” сэдэвт сургалт онлайнар хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Б.Баттуяа нар хамрагдсан.

11.Нийгмийн даатгалын газраас 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Даатгуулагчдын зөвлөгөөн”-д ерөнхий нягтлан бодогч У.Буянбат оролцсон

12.УБЕГ-аас зохион байгуулсан Мэдээлэл технологийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд П.Азжаргал танхимын сургалтанд хамрагдсан.

13.Мобиком үүрэн телефоноос 2025 оны 05 дугаар сарын 02 өдөр албан хаагчдад мэдээ мэдээллээр ханган сургалт хийсэн

14.УБЕГ-т 2025 оны 05 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн тасгийн /ахлах/, бүртгэгч нарт зориулсан мэргэжил арга зүйгээр дэмжих сургалтад Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Б.Баттуяа, Д.Мөнхцэцэг нар хамрагдсан.

15.2025 оны 05 сарын 17-18-ны хооронд Дорнод аймагт болсон “Мэргэжлийн тасралтгүй хөгжил 2025 ” зүүн бүсийн салбаруудын мэргэшсэн нягтлан бодогчдын сургалт зөвлөгөөнд Ерөнхий нягтлан бодогч У.Буянбат хамрагдсан.

16.Хүний эрхийн үндэсний комиссын Дорноговь аймгийн төлөөлөгч Т.Мөнгөнчулуун 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр “Хүн бүр хүүхэд хамгаалагч” сэдэвт сургалтанд хэлтсийн албан хаагчид хамрагдсан.

17. Прокурорын байгууллагын хамтарсан багийн хяналтын улсын байцаагч нарын зөвлөгөөнд хяналтын улсын байцаагч Э.Уранбилэг 2025 оны 06 сарын 6-нд оролцсон.

18.УБЕГ-аас 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн эрхзүйн сургалт, 06 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан тоног төхөөрөмжийн сургалтанд Айраг, Дэлгэрэх, Сайхандулаан сумын улсын бүртгэгч нар хамрагдсан.

19.УБЕГ-аас 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээл ба тэгшж байдал” онлайн сургалтанд хэлтсийн албан хаагчид

20.Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Тэнгэрийн хутагт” фестивалийн сургалтанд Иргэний улсын ахлах бүртгэгч Б.Баттуяа,

21. Аймгийн ЗДТГ болон Хурдан төвөөс 2025 оны 09 сарын 24-ний өдөр зохион байгуулсан Харилцаа холбоо мэдээлэл технологийн хэлэлцүүлэг танхимын сургалтанд мэдээллийн технологийн ажилтан хамрагдсан.

22.Тус хэлтсийн хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ нь УБЕГ-ын даргын 2025 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/172 дугаар тушаалын дагуу төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, дадлагажуулах сургалтанд хамрагдаж байна.

23.УБЕГ-аас 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр “Үйлчилгээний ур чадвар олгох онлайн сургалт

24. УБЕГ-аас 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан онлайн сургалт

25.Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар онлайн сургалт, Аймгийн ЗДТГ болон өмгөөллийн “Легал гайд” хуулийн фирмтэй хамтран бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт сургалтанд хэлтсийн 4 албан хаагч хамрагдсан

26. Хүний эрхийн үндэсний комиссоос 10 дугаар сарын 22-ны өдөр “Хүний эрхийн индексийн үзүүлэлтийг хэлэлцүүлэх” уулзалтанд Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Б.Баттуяа хамрагдсан. Хүний эрхийн үндэсний индекс тооцох аргачлал, Хүний эрхийг хангах үндэсний хоёрдугаар хөтөлбөрийн төслүүдийг танилцуулах, санал солилцох хөтөлбөрт ХЭ,ЭХЭУБ-ийн тасгийн дарга Г.Батсайхан, архивч Ц.Наранчимэг, мэдээлэл технологийн ажлант П.Азжаргал нар хамрагдлаа.

27.Орон нутгийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй” сэдэвт сургалтыг /2025.10.22/ зохион байгууллаа. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол болон Үр дүнд суурилсан төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагналтын талаарх сургалтад Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Б.Баттуяа танхимаар хамрагдлаа.

28.УБЕГ-аас 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Брэндбүүк” танилцуулах сургалтанд хэлтсийн дарга, мэдээлэл технологийн ажлант нар хамрагдсан.

29.УБЕГ-аас 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдөр зохион байгуулсан “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдэвт онлайн сургалт

30.УБЕГ-аас 2025 оны 11 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хууль зүй дотоод хэргийн салбарын санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн системийг хөгжүүлэх” танхимын сургалтанд ахлах нягтлан бодогч У.Буянбат хамрагдсан.

31.УБЕГ-аас 2025 оны 11 дүгээр сарын 05-нд зохион байгуулсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал, нотариатын зуучлалаар эрхийн улсын бүртгэл хөтлөх мэдлэг олгох тухайн онлайн сургалтанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар.

32. Хууль зүй дотоод хэргийн яамны Жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Төрийн албаны удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалт”-д хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ хамрагдсан.

33. Аймгийн ЗДТГ-аас 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд зөвлөн туслах үйлчилгээ” танхимын сургалтанд хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, бичиг хэргийн эрхлэгч нар хамрагдсан.

34.Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан “Төрийн болон албаны нууц, түүний хадгалалт хамгаалалтын тухай” онлайн сургалт

35.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем”-д ажиллах арга зүйн танхимын сургалтанд Ахлах нягтлан бодогч У.Буянбат, өмч хамгаалах “Байнгын зөвлөл”-ийн гишүүн Д.Баярсайхан нар сургалтанд хамрагдав.

36.Тагнуулын ерөнхий газраас 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Кибер аюулгүй байдал” танхимын сургалтанд мэдээллийн технологийн ажилтан хамрагдсан.



Тайлант онд Улсын бүртгэлийн хэлтсээс дараах сургалтуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

1. Нийт сумдын 14 улсын бүртгэгч нарт 2025 сарын 03 дугаар сарын 14-ний өдөр “Иргэн, хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал” онлайн сургалт зохион байгуулсан

2.Дорноговь аймгийн Татварын газарын албан хаагчдын нэгдсэн сургалт зөвлөгөөнд ХЭ,ЭХЭУБ-ийн тасгийн дарга Г.Батсайхан, Хуулийн этгээдийн бүртгэгч Ж.Болортуяа, ИБ-ийн тасгийн дарга Б.Баттуяа нар холбогдох хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулсан.

3.2025 оны 04 дүгээр сарын 09-өөс 11-ний хооронд сумдын бүртгэгч нарт сургалт зөвлөгөөн хийж хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ сургалт мэдээлэл өгч ажилласан. Мөн төрийн албаны салбар зөвлөлийн дарга Н.Баттуяа “Төрийн албны ёс зүй”, Тагнуулын мэргэжилтэн Д.Энхбаяр, “Авилгаас урьдчилан сэргийлэх” чиглэлээр ХЗХ мэргэжилтэн Г.Эрдэнэбаяр нар тус тус сургалт өгсөн.

4.Улсын бүртгэлийн хэлтсийн даргын санаачилгаар хойд бүсийн сургалт зохион байгуулах тухай удирдамжийн дагуу хэлтсийн албан хаагч, бүртгэгч нарт зориулсан сургалтыг 2025 оны 07 сарын 04-нд Иххэт суманд зохион байгуулсан.

5.Өмнөд бүсийн сургалт зохион байгуулах тухай удирдамж боловсруулан улсын бүртгэлийн хэлтсийн ажилтан албан хаагч, бүртгэгч нарт зориулсан сургалтыг 2025 оны 09 сарын 11-нд Замын-Үүд суманд тус тус зохион байгуулсан байна.

6.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн хүрээнд хэлтсийн 14 албан хаагчид цахим тестэд хамрагдсан. Мөн Хууль зүй дотоод хэргийн яамны Жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Төрийн албаны удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалт”-д хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ тус тус хамрагдсан.



2.8 Санхүү, аж ахуйн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил:

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 оны 11 сарын байдлаар 293,210.9 мянган төгрөгийн үйлчилгээний орлогыг олж 292,002.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн орон нутгийн төсөвт торгууль, шийтгэлийн орлогоор 9780.0 мянган төгрөг, тэмдэгтийн хураамжаар 136,949.0 мянган төгрөг, үл хөдлөх борлуулсны орлогоор 1,809,316.4 мянган төгрөг нийт 1,956,045.4 мянган төгрөгийн орлого оруулсан байна.

Тус хэлтсийн зардлын төсөв 2025 онд 1,318,471.0 мянган төгрөгөөр батлагдсан. Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр бүтээлтэй зарцуулах, хуваарилах, төлөвлөх ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд төсөв дүн хэтрээгүй, 10 дугаар сарын байдлаар 1,099,303.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 1,040,990.4 мянган төгрөгийг зохих зардлуудад төсвийн хуваарийн дагуу зарцуулан 58,313.3 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн программ ашиглаж олон улсын стандартад нийцүүлэн хөтөлж, байгууллагын мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хүрээнд байнгын хяналт тавьж, төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг 10 удаа хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж СТСХэлтэст болон УБЕГ-ын СААХ-т хүргүүлсэн. 2025 оны 1-р улирлын санхүүгийн тайланг гаргаж,

УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн. 2024 оны санхүүгийн тайлангийн аудит түүврээр орсон. Акт албан шаардлагагүй зөрчилгүй ажилласан гэж дүгнэгдсэн.

2025 онд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын нөхөн сонгуулийн зардалд 4,602.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан.

УБЕГ-аас болон бусад байгууллагаас 18,631.4 мянган төгрөгийн үнэт цаас, маягт болон 11,485.0 мянган төгрөгийн бусад бараа материалыг бэлтгэж хангалтыг тасалдуулалгүй, мөн бараа материалыг хэмнэлттэй ашиглаж зарцуулсан.

2025 оны 11 сарын байдлаар 143 төрлийн 596 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан.

Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь үндсэн хөрөнгө орлого авах, үнэт цаасны тооллого, хүчингүй болгосон үнэт цаас, үнэт цаасны зарцуулалт зэргээр 6 удаа хуралдаж шийдвэр гаргаж ажилласан.

Аймгийн Засаг даргын 2024 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн А/380 тоот захирамжаар орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдыг урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор улсын төсвөөс санхүүждэг зарим агентлаг, байгууллагын албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 20 хувиар тооцон 2025 оны 1 сард орон нутгийн төсвөөс нэмэгдэл цалин, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардалд 9,707.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, албан хаагчдад олгоод байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн А/420 тоот захирамжаар орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдыг урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор улсын төсвөөс санхүүждэг зарим агентлаг, байгууллагын албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 20 хувиар тооцон 2025 оны 2-9 сард орон нутгийн төсвөөс нэмэгдэл цалин, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардалд 61727.47 мянган төгрөг, нийт 71,435.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, албан хаагчдад олгоод байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар ашиглалтын хугацаа дууссан ч цаашид ашиглах боломжтой 7 нэр төрлийн 33 ширхэг 26,124.0 мянган төгрөгийн хөрөнгийг 7,700.0 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоох саналыг УБЕГазраар дамжуулан ТӨБЗГазарт хүргүүлсэн. ТӨБЗГ-ын 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 318 дугаар тогтоолоор 7,700.0 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон 7 нэр төрлийн 33 ширхэг хөрөнгийн үндсэн хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэлд тусгасан.

- Байгууллагын 2025 оны 1 дүгээр улирал, хагас жилийн болон 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт;
- Нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн тайлан;
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг цаг хугацаанд нь;
- Сангийн сайдын тайлан, мэдээ гаргах тушаалын дагуу сар бүр төсвийн гүйцэтгэл, өр авлагын мэдээ;

- Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын мэдээг тус тус гарган ажилласан. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн төрийн санд сар бүрийн 2-нд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр бүтээлтэй зарцуулах, хуваарилах, төлөвлөх ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд төсөв дүн хэтрээгүй хэмнэлттэй ажилласан байна.

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг сар бүр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүүгийн хэлтэст хүргүүлж, шинээр үүссэн өр авлагагүй ажилласан.

2.9 Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:

2.9.1 Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Тайлант хугацаанд 1144 албан бичиг хүлээн авч edoc програмд бүртгэснээс хариутай бичиг 662, хариугүй албан бичиг 482 ирүүлсэн байна. Албан бичгийн шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд ирсэн бичгийн шийдвэрлэлт 89.8%-тай байна.

Мөн edoc болон цаасаар 971 албан бичгийг боловсруулан бусад байгууллагад хүргүүлсэн байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн програмаар илгээж бусад албан бичгүүдийг шуудангаар холбогдох газарт нь хүргүүлэн ажиллаж байна.

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн журмын төсөл, Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, дүрмийг төслийг боловсруулж тушаалаар батлуулсан.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан БНШК-ын хурлаар хэлэлцэж, аймгийн БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэхээр хэлтсийн 2025 оны 18/160 дугаар албан бичгээр хүргүүлэн, БНШАЗК-ын 2025 оны 02 дугаар хурлаар хэлэлцэн батлуулсан. /Архивын тасгийн 2025 оны 66/37 дугаар албан бичгээр хариуг хүлээн авсан/.

Хэлтсийн 2024 онд хөтлөгдсөн баримтыг Хяналтын улсын байцаагч, нягтлан бодогч, бичиг хэрэг, бусад холбогдох ажилтнаас 2024 оны УИХ-ын болон аймаг, орон нутгийн сонгуулийн баримт үдэж, Байнга-27, Түр-199, 70 жил-6 хадгаламжийн нэгж болгон архивласан.

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн журмын төсөл, Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, дүрмийг төслийг боловсруулж, хэлтсийн даргад танилцуулж тушаалаар батлуулсан.

Хэлтсийн 2021-2024 оны байнга болон түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, Нягтлан шалгалтын явцад хадгалах хугацаа дууссан, түүх эрдэм

шинжилгээний ач холбогдолгүй 2007-2021 оны устгах баримтын жагсаалтыг гарган хянуулахаар аймгийн Архивын тасагт төслийг хүргүүлсэн.

“Архив, албан хэрэг хөтлөлтийн соёлыг дээшлүүлье” аяны төлөвлөгөөний биелэлт, Архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт, ашиглалтын талаарх мэдээг гаргаж аймгийн ЗДТГ-ын Архивын тасагт, байгууллагын архивын цахимжуулалтын судалгааг гаргаж УБЕГ-т цахимаар хүргүүлсэн.

2.9.2 Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:

Тус хэлтэст 2025 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар иргэн, хуулийн этгээдээс нийт 57 санал хүсэлт, талархал, гомдол ирсэн байх бөгөөд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй буюу 100 хувь шийдвэрлэн ажилласан.

Иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль, журмын хүрээнд нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу өгөх жишиг тогтоох үйл ажиллагааг эрчимжүүлэн ажилласан.

2.9.3.Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэл ажлын хүрээнд:

Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан удирдамжийн удирдлага болгон аймгийн Засаг даргын 2025 оны А/551 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийг зохион байгуулав.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажлын хэсгийн ахлагч Ц.Батсугир, гишүүд С.Ариунсайхан, А.Оюумаа нар ажилласан.

Ажлын хэсэг нь Дорноговь аймгийн УБХ-ийн 2020-2025 оны баримтуудад тулгуурлаж Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан улсын үзлэгийн шалгуур үзүүлэлт, аргачлалын дагуу тус байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн шалгуур тус бүрээр оноо өгч үнэлгээ дүгнэлт өгч ажилласан.

Ажлын хэсэг байгууллагын архивын үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, ажлын зохион байгуулалт гэсэн 3 шалгуурын дагуу төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны хэрэгжилтийн түвшнийг үнэлэх, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан.

Төрийн ажлын зохион байгуулалт 90%, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа 90%, архивын үйл ажиллагаа 91%-тай тус тус дүгнэгдсэн.

2.10. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Хэлтсийн тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, ашиглалтад хяналт тавих, мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт,

бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системүүдийн хэвийн найдвартай ажиллагаа, программ болон сүлжээний аюулгүй байдал техник хангамжийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын системээр хүний нөөцийн удирдлага, цаг бүртгэл, мэдээ мэдээлэл, ажлын хэсэг, өргөдөл гомдол, байгууллагын архив, албан хэрэг хөтлөх, дотоод мессенжер зэрэг өргөн боломжтой цогц системийг албан хаагч нарт хандах эрхийг тохируулан ажилласан.

Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор ажлын цаг бүртгэлийг Егр системээр 2025 оны 04 дүгээр сараас эхлэн бүртгэж хяналт тавин ажиллаж байна.

2.11. Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах сурталчилах ажлын хүрээнд:

2.11.1 Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал

Байгууллагын ил тод нээлттэй, шуурхай хариуцлагатай байдлыг хангаж, төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилж мэдээлэх, иргэдийн санал бодлыг сонсох, “Нээлттэй хаалганы өдөр”, иргэдэд чиглэсэн бусад үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ил тод, нээлттэй, хариуцлагатай, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилтуудыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 352 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Нээлттэй мэдээллийн ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур, үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу байгууллагын эрхэм, зорилго, тэргүүлэх чиглэл болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, мэдээ, мэдээллийг “Мэдээллийн самбар”, цахим дэлгэц, хэлтсийн цахим хуудас, фэйсбүүк хуудсанд бүрэн байршуулж, мэдээллийг тухай бүрт шинэчлэн ойлгомжтой байдлаар байршуулсан.

Байгууллагын хэмжээнд иргэдийг цагийн хуваариар хүлээн авч, санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна.

Хэлтсийн нийт албан хаагчид болон өргөдөл, гомдол хүлээн авах ажилтны мэдээллийг хэлтсийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний 268 мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.

2.11.2. Байгууллагын албан ёсны цахим хуудас пэйж хуудсаар сурталчилсан байдал:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл болон хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг бүхий л арга хэлбэрээр шуурхай хүргэхийн зэрэгцээ бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг дараах байдлаар сурталчлан ажилласан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний 268 мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.

Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл өгч, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлэн ажилласан. Тухайлбал:

Аймгийн хэмжээнд “Мэдлэг түгээ”, “Мэдээлэл түгээ” аяныг эхлүүлэн үе шаттайгаар зохион байгуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд хэлтсээс үзүүлж буй хугацаатай бүртгэлийн мэдээллийг иргэд, олон нийтэд мэдлэг олгох үүднээс “МЭДЛЭГ ТҮГЭЭ” аян, байгууллагаас гарч байгаа мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилан “МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭ” аяныг зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 10 сарын статистик тоон мэдээ, контент-3, рийл, видео ярилцлага-15, постер-49, пост-39, УБЕГ болон бусад мэдээ, мэдээллийг цахимд байршуулж 725701 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.



“Танд ойрхон төрийн үйлчилгээ” арга хэмжээг нийт 10 суманд 16 удаагийн арга хэмжээ зохион байгуулж ажилласан. Үүнд

- Сайхандулаан суманд 02 дугаар сарын 03-нд, 5 сарын 20-нд,
- Эрдэнэ суманд 04 дугаар сарын 29-нд, 06 дугаар сарын 06-нд,
- Даланжаргалан суманд 02 дугаар сарын 17-18, 03 дугаар сарын 19-25-ны өдрүүдэд,
- Хатанбулаг суманд 06 сарын 03-06-ны өдрүүдэд,
- Хатанбулаг сумын Ханги мандалын боомтод 10 дугаар сарын 09-ний өдөр
- Өргөн сум 02 дугаар сарын 15, 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд,

- Иххэт суманд 05 дугаар сарын 23-ны өдөр, 07 дугаар сарын 04-ний өдөр,
- Улаанбадрах суманд 01 дүгээр сарын 21, 05 дугаар сарын 19,20-ны өдрүүдэд нээлттэй хаалганы өдөрлөг,
- Замын-Үүд суманд 09 дүгээр сарын 11-ний өдөр
- Сайншанд суманд 05 дугаар сарын 01-ний өдөр “Танд ойрхон төрийн үйлчилгээ” өдөрлөгийг тус тус зохион байгуулж нийт 2014 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.



2.11.2 Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал:

Энэ хүрээнд <https://www.dornogovi@burtgel.gov.mn> байгууллагын цахим хуудаст хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, Байгууллагын бүтэц, орон тоог баталсан тушаал, баталсан орон тоонд ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл, албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаал, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм, хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

2.11.3 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал:

Тус байгууллагын шилэн дансанд [/https://www.dornogovi@burtgel.gov.mn/](https://www.dornogovi@burtgel.gov.mn) нийт 238 мэдээллийг байршуулсан. Мөн хэлтсийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг байршуулсан. Санхүүгийн тайлангийн аудитАудитын түүврийн аргаар хийгдсэн зөрчил илрээгүй.

2.11.4 Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал:


Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж хэвшсэн.

2.11.5 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал:

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг байгууллагын албан ёсны сайтад байршуулсан.


2.11.6 Улсын бүртгэлийн байгууллагын “Үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд:

Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбар, чирэгдэлгүй, түргэн, шуурхай, тохь тухтай орчинд бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд иргэдийг хүлээн авах үйлчилгээний танхимд тавигдах нийтлэг шаардлагыг бүрэн ханган ажилласан.






Үйлчлүүлэгчийг хүлээн авах цонх

Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлэх болон бусад үйлчилгээ авахаар бага насны хүүхдээ дагуулан ирж байгаа иргэдийн ая тухтай үйлчлүүлэх нөхцөлийг ханган, “Хүүхдэд ээлтэй орчин”-г бүрдүүлж, нярай хүүхдийн ор, саатуулах сандал 2 ширхэгийг байршуулсан




%Тус хэлтсийн үйлчилгээний зааланд иргэд дарааллын дагуу үйлчлүүлэх боломж бүрэн бүрдсэн байдал



Цаг хэмнэсэн - Цахим үйлчилгээ булан”-ийн мэдрэгч бүхий дэлгэцээр Э-Монголиа цахим хаягт нэвтэрч лавлагаа, үйлчилгээг авах мөн иргэдийг

шаардлагатай тохиолдолд бичиг баримт хувиан олшруулах боломжоор бүрэн хангасан. Мөн үйлчилгээний төлбөр төлөх Гэрэгэ киоск машинаар 1230 төлбөрийн гүйлгээ хийгдсэн байна. Иргэд үйлчилгээний заал болон банкинд оочирлохгүйгээр төлбөр тооцоо хийх болсноор иргэдийн цагийг хэмнэсэн чухал булан болсон.



Хэлтсийн үйлчилгээний зааланд гар утас цэнэглэх нийтийн булан буюу Charging zone байршуулсан. Тус цэнэглэгч нь нэг дор 6 гар утас зэрэг цэнэглэх боломжтой юм.




Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Соёмбо цогцолборт “24/7 цахим үйлчилгээний төв”-д цагийн хязгаарлалтгүй улсын бүртгэлийн үйлчилгээг 1230 иргэнд үзүүлсэн байна.



2.11.7 Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаа:

Улсын бүртгэлийн нэгжүүдээс үзүүлж буй улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, нэгжийн зохион байгуулалтын бүтцэд дүгнэлт хийх, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх, албан хаагчдын харилцаа хандлагыг дүгнэх зорилгоор харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааг QR код үүсгэн тус хэлтсийн үйлчилгээний танхимд байршуулж, 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар цахимаар авсан. Судалгаанд 274 харилцагч хамрагдсан.


Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийн асуулганд 99.6% хүссэн үйлчилгээгээ авч чадсан.



Улсын бүртгэлийн ажилтны соёл, үйлчилгээний асуулганд Улсын бүртгэлийн ажилтны харилцаа, хандлага ёс зүй, мэргэжлийн ур чадварыг 91.9% сайн гэж үнэлгээ өгсөн байна.



Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-79.9%, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-15%, хуулийн этгээдийн улсын бүртгэл-5.1% улсын бүртгэлийн ямар чиглэлээр үйлчилгээ авсан байна.



Манай байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад ямар ажил арга хэмжээ зохион байгуулвал үр дүнтэй байх талаар санал авахад:

-Үйлчилгээний стандартад нийцсэн байртай болох, Ажлын оффис шинээр бий болгох, Нээлттэй хаалганы өдөрлөг тогтмол зохион байгуулах, зөөврийн тоног төхөөрөмжийн үйлчилгээг хүргэх, сүлжээ удаашралтай, сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, хяналтын улсын байцаагчийн орон тоог нэмэгдүүлэх, ханги хилийн боомтод тогтмол ирж ажиллах зэрэг санал хүсэлтүүдийг ирүүлсэн байна.

ГУРАВ. УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2025 оны 10 сарын 25-ны байдлаар аймгийн хэмжээнд нийт 18076 иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн байна.

3.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх чиглэлээр 30443 иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- Төрсний бүртгэл- 832
- Гэрлэсний бүртгэл-219
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-79
- Үрчилсний бүртгэл-10
- Овог, эцэг эх –ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл-51
- Эцэг, эх тогтоосны бүртгэл-36
- Нас барсны бүртгэл-352
- Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл-2435
- Иргэний үнэмлэхний бүртгэл-517
- Үндэсний энгийн гадаад паспорт олголт-6358
- Нэг удаагийн хавсралт-95
- Олон удаагийн хавсралт-9037
- Аймаг хотоос шилжин ирсэн-1521
- Хот доторх шилжилт хөдөлгөөн-3308
- Иргэнд лавлагаа олголт-4370
- Албан хэрэгцээнд лавлагаа олголт -692
- Хууль хяналтын байгууллагад-531

3.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх чиглэлээр 7521 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- Анхны бүртгэл-992
- Өмчлөх эрх шилжих гэрээ-1442
- Барьцааны гэрээ-4606



- Бусад гэрээ-23
- Бүртгэлд өөрчлөлт оруулах-348
- Лавлагаа, хуулбар- 108
- Урьдчилсан тэмдэглэл-2
- Эдгээр үйлчилгээг хийснээр үйлчилгээний хураамж 136,949,019 төгрөг тэмдэгтийн хураамж 20,215,987 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 2 хувь болох татвар 1,809,316,445 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.

3.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх чиглэлээр 1567 хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

- Шинээр байгуулсан хуулийн этгээдийн бүртгэл-257
- Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл-311
- Хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газар шинээр бүртгүүлсэн-22
- Хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалт-531
- Хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаар олгосон-316
- Хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдгийн бүртгэл-31
- Лавлагаа, хуулбар олгосон -83
- Шүүхийн шийдвэрээр хориг тавьсан, цуцалсан бүртгэл-16

3.4. Зөөврийн тоног төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг дараах байдлаар үзүүлсэн байна.

Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр Улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд чирэгдэлгүй, хурдан шуурхай хүргэх зорилгоор зөөврийн тоног төхөөрөмж ашиглан хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн албан бичиг, хүсэлтийн дагуу 11 иргэний биеийн давхцалгүй өгөгдлийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн цахим иргэний үнэмлэхийг олгосон



3.5 Иргэдийг бичиг баримтжуулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хилийн цэргийн анги болон бусад хил хамгаалах чиг үүргийн болоод хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд, тэдгээрийн ажилтан, алба хаагчдад улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, 180 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа иргэдийн хаягийн зөрчлийг арилгах,

бичиг баримтгүй иргэдийг бичиг баримтжуулах зорилгоор “Бүрэн бүртгэл” аяны удирдамжийн төслийг боловсруулан 2025 оны 07 дугаар сард 1 сарын хугацаатай аян зохион байгуулсан.

Уг аяны хүрээнд Айраг суманд үйл ажиллагаа явуулж байгаа 32 аж ахуй нэгж, байгууллагуудаас 330 албан хаагчдын хаягийн судалгааг авч хаягийн зөрчилтэй 67 иргэний судалгааг гаргасан.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй болон бичиг баримтгүй иргэдийн судалгааг гаргах, багийн бүртгэл мэдээллийн ажилтнуудтай хамтран багийн хүн амын судалгаанд тулгуурлан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулгалт хийж иргэний улсын бүртгэлийн үндсэн санд нэрийн галиг, гэрлэлтийн байдлын төлөвт алдаатай бүртгэгдсэн 77 иргэний хүсэлтийг хүлээн авч мэдээллийн санд засварласан. Мөн огт бичиг баримтгүй Сайншанд, Замын-Үүд, Айраг 3 иргэнийг бичиг баримттай болгосон.

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 85 жилийн ойн хүрээнд Дорноговь аймгийн 14 сумын хэмжээнд иргэний бүртгэлийн мэдээллийн сангийн цахимжуулалтыг нэмэгдүүлэх, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, сумдын улсын бүртгэгч нарын үйл ажиллагааг идэвхижүүлэхээр “Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх, нөхөн бүртгэл хийх” уралдааныг зарлаж цахимжуулаагүй болон программын хөрвүүлэлтээс шалтгаалан мэдээлэл дутуу, алдаатай бүртгэгдсэн мэдээллийг засах, 1951-1988 оны төрсний, гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны, эцэг /эх/ тогтоосны, үрчилсний, овог нэр, өөрийн нэр өөрчилсний, нас барсны бүртгэлийг нөхөн бичиж иргэний улсын системд бүртгэх ажлын хүрээнд эх нотлох баримт бичиг, иргэний улсын бүртгэлийн маягтыг үндэслэн төрсний бүртгэл-150, гэрлэлтийн бүртгэл-13, нас барсны бүртгэл-1, нийт 164 бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шивж баталгаажуулсан.

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Танд ойрхон төрийн үйлчилгээ” нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэн Д.Эрдэнэсайханыг бичиг баримтжуулсан.



3.6. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд:

Тайлант онд нийт 6647 тоон гарын үсгийг иргэдэд олгосон бөгөөд улсны бүртгэгч нар 4643 иргэнд, Хаан банк киоск машинаас 849 иргэнд, Төрийн цахим үйлчилгээний төвөөс 1155 иргэнд тус тус тоон гарын үсгийг олгосон байна.

Улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ойртуулж, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх, мэдээ мэдээлэл, зөвлөмж, зөвлөгөө өгөх, тоон гарын үсгийн ач холбогдлыг сурталчилан таниулах болон тоон гарын үсэг олгоход төр, хувийн хэвшил, иргэний хамтын ажиллагааг нэмэгдүүлэхээр “Тоон гарын үсгээ тогтмол хэрэглье” арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулсан. Тус арга хэмжээг батласан удирдамжийн дагуу Хаан банк, Төрийн банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банкны аймаг дахь салбаруудтай хамтран үйлчилгээ авч буй иргэдэд тоон гарын үсгийн ач холбогдлыг сурталчилан таниулах, тоон гарын үсгийг олгож ажилласан.

Мөн үүрэн телефоны Юнител компанитай хамтран ажиллаж “one call” үйлчилгээний дуудлага хэсэгт хэрэглээ ач холбогдлыг талаарх богино яриаг байршуулан ажилласан.

Мөн тухайн онд Сайншанд, Замын-Үүд, Айраг, Дэлгэрэх, Хатанбулаг зэрэг сумдад нийт 16 удаагийн нээлттэй арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд тоон гарын үсгийг тухай бүр олгон ажилласан.

3.7. Улсын бүртгэлийн нэгдсэн архивын чиглэлээр:

Иргэний улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

Аймгийн хэмжээнд 14 суманд хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн ИУБ маягтын 8 төрлийн 4531 ш “Б” тал,орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсээс нийт 822 иргэний хувийн хэргийг тус тус хүлээн авсан.

Хүлээн авсан 4531 ширхэг ИУБ маягтыг цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан, архивын сан хөмрөг болох ИУБ маягтуудыг холбогдох хадгаламжийн санд байрлуулаад байна. 3718 ИУБ маягтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нягтлан шалгаж, нас барсан 352 иргэний хувийн хэргийг нас барсны бүртгэлийн санд тус тус шилжүүлэн байрлуулсан.

Тус хэлтсийн иргэний баримтын архивын сан хөмрөгт хөтлөгдөх баримт ашиглалт, чийг дулаан хэмжих, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, галын хор шалгах тэмдэглэл, бүртгэлийг шинэчлэн баталж хяналт тавьж ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

Тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 26574 хувийн хэрэг шинээр, 761 хувийн хэрэгт бүртгэлийн эх нотлох баримтын баяжилтаар нэмэгдсэн.

Эд хөрөнгийн бүртгэл хөтлөх эрх авсан сумын улсын бүртгэгч нарт бүртгэгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримтын баяжилтыг долоо хоногт 2 удаа авч баяжилтыг хийсэн.

Нийт 4972 ширхэг бүртгэлийг архивын сан хөмрөгт байршуулсан байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн архивын сан хөмрөгт байрлах эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн баримтыг зориулалтын цаасан хайрцгаар сольсон.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Тус хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэлийн архивт 232 хувийн хэрэг шинээр, 3061 хувийн хэрэгт бүртгэлийн эх нотлох баримтын баяжилтаар нэмэгдсэн.

ДӨРӨВ. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх 16 заалт бүхий төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр боловсруулан, хэлтсийн даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

Тайлант хугацаанд бүртгэлийн хяналтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Бүртгэлийн хяналтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөгөөт шалгалтыг 4 удаа гүйцэтгэсэн.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2151, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 239, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 42 бүртгэлийг шалгаж, нийт 2432 зөрчил илрүүлэн арилгуулах арга хэмжээ авч ажиллав.

Бүртгэлийн зөрчлийг арилгахаар иргэд болон улсын бүртгэгчдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт, тайлбарын дагуу иргэний улсын бүртгэлтэй холбоотой 9, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 49, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 3 нийт 161 дүгнэлтийг боловсруулан зөрчлийг арилгасан. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэсэн.

Бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалт болон сар бүрийн мэдээ, судалгааг нэгтгэн гаргаж илэрч буй алдаа, зөрчилд дүгнэлт хийж, зөрчлийг давтан гаргуулахгүй байх үүднээс улсын бүртгэгчдэд дотоод албан бичгээр 1 удаа чиглэл, зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. Мөн дүгнэлтээр засагдаж буй улсын бүртгэгчдийн гаргасан зөрчлийн судалгааг бүртгэгч тус бүрээр гаргаж санамж анхааруулга өгч байна.

Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 309 иргэн, 8 хуулийн этгээдэд холбогдох 317 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 10.520.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан байна.

Аймгийн хэмжээнд шийдвэрлэгдэж буй зөрчлийг сумдаар нь болон төрлөөр нь ангилан сар, улирлаар судалгаа гаргаж ажилладаг. Тайлант хугацаанд хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн 309 зөрчлийн хэрэг материалыг аймгийн Прокурорын газарт хуулийн хугацаанд бүртгүүлж, хянуулсан.

Зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдын улсын бүртгэгч нартай хамтран ажиллаж хугацаатай бүртгэлүүдээр иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж сар бүр хийсэн ажлын мэдээ, үр дүнг тооцож ажиллаж байна.

ТАВ. СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

5.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Айраг сумын 4 дүгээр тойрог, Дэлгэрэх сумын 2 дугаар тойрог, Сайхандулаан сумын 4 дүгээр тойрогт тус тус зохион байгуулахтай холбогдуулан сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг сонгуулийн нэгдсэн программд цахимжуулан оруулж санал авах байрыг Мэдээлэл технологийн газраас ирүүлсэн зааварчилгааны дагуу байршуулсан.

Дээрх 3 сумын сонгогчийн нэрсийн жагсаалтыг улсын бүртгэгч нар хувиарлан сонгогчдын мэдээлэл болон сонгогч нэрсийн жагсаалтад бүрэн хамрагдсан эсэхийг нягтлан шалгахад 2024 оны 11 дүгээр сараас хойш шилжин ирсэн, явсан, нас барсан иргэдийн мэдээлэл шинэчлэгдээгүй байсан тухай зөрчил илэрч, Мэдээлэл технологийн газарт яаралтай мэдэгдэж зөрчлийг арилгасан.

Сонгогчийн нэрийн жагсаалтад байгаа “Түр хасав” төлөвтэй 92 иргэдийн мэдээллийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд дээрх сумдын бүртгэгч нарт нэрсийг хүргүүлэн багийн Засаг дарга нартай хамтран тулган шалгалаа. Гадаад улсад 60 хоногоос дээш хугацаанд зорчсон 15 иргэний төлөвийг сэргээх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Хорих ангид, эрүүгийн хэрэг, албадан эмчлүүлсэн болон эрх зүйн чадамжгүй иргэдийн төлөвийг сэргээх хүсэлт ирүүлээгүй болно.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг улсын ахлах бүртгэгч Б.Баттуяа 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр 10 цаг 17 минутад Айраг сумын 4 дүгээр тойргийн 1397, Дэлгэрэх сумын 2 дугаар тойргийн 433, Сайхандулаан сумын 4 дүгээр тойргийн 209 сонгогчын нэрийн жагсаалтыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 10 цаг 48 минутад тус тус хэвлэж дууссан.

Дээрх 3 сумын сонгогчийн нэрсийн жагсаалтыг Хяналтын улсын байцаагч Э.Уранбилэг, ахлах бүртгэгч Б.Баттуяа нар хуудас тус бүрийг шалгаж, акт үйлдэн хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ гарын үсэг зурж тэмдгээр баталгаажуулж, сонгуулийн хэсгийн хороодод хүргэж өгөх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.

Дээрх 3 сумын сонгогчийн нэрсийн жагсаалтыг 2025 оны 05 сарын 27-ноос 2028 Хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ, Хяналтын улсын байцаагч Э.Уранбилэг, ахлах бүртгэгч Б.Баттуяа, Г.Батсайхан нарын бүрэлдэхүүнтэйгээр сумын сонгуулийн хороодын дарга нарт хүлээлгэн өгч акт үйлдсэн.

ЗУРГАА. БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ

Тус хэлтэс нь өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Дорноговь аймаг дахь Тагнуулын хэлтэс, аймгийн Засаг даргын Тамгын газар, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар, болон хууль хяналтын болон холбогдох төрийн бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Мөн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Гэрэгэ системс” ХХК, “Монгол Шуудан” ХХК хамтран ажиллалаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Н.Алдарбаяр болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нутгийн удирдлагын хөгжлийн хорооны төлөөлөгч У.Ганбаатар, С.Дамдинсүрэн, Хот суурин, дэд бүтцийн хөгжлийн хорооны төлөөлөгч Д.Тулга, Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооны төлөөлөгч Т.Гантулга, Д.Мөнхбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Улсын бүртгэлийн хэлтсийн удирдлагууд, албан хаагчидтай 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр уулзлаа.

Уулзалтаар тус байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлаар санал, хүсэлтийг сонсож цаашид авч хэрэгжүүлэх ажлын



талаар санал солилцлоо.

Монгол Улсын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд аймгийн Засаг даргаас агентлаг, байгууллагын дарга нартай хамтран ажиллах чиглэл, талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, Засгийн газраас эрх шилжүүлсэн

зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, Төрийн алба болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулж, ашиг сонирхлын зөрчилгүй, төсөв санхүүгийн зөв менежментийг хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор хамтран ажиллах гэрээг байгуулсан.

“Монгол банк”, “Голомт банк”, “Төрийн банк”, “Капитрон банк”, “Хаан банк”, “Хас банк”, “Худалдаа хөгжлийн банк”, “Юнител”, “Мобиком”, “Скайтел” зэрэг байгууллагуудын удирдах ажилтнуудтай 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр уулзаж улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаар нэгдсэн ойлголттой болох, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх талаар нээлттэй хэлэлцүүлэг хийсэн.



Дорноговь аймаг 2025 оны зорилтот жилээ “Аялал жуулчлалыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “ИХ ГОВИЙН ТЭМЭЭ-2025” улсын зөвлөгөөн, тэмээчдийн баяр 2025 оны 02 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын “Хилэнцэт хөшөө” гурван замын уулзварт зохион байгуулагдсан. Уг арга хэмжээнд Хурдан атны уралдаан, Шилмэл буур, Шилмэл ингэ, Поло, Буухиа, Сайхан тэмээтэй сайхан хос, Ойрын зайн уралдаан, Хурдан торомны уралдаан, Тэмээчдийн ур чадварын тэмцээн зэрэг төрлүүдэд 6 аймгийн баг тамирчид оролцсон бөгөөд тус хэлтсээс баг, тамирчдын бүртгэлийг шалгаж бүртгэлжүүлэн ажилласан.



Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 104 жилийн ойн хүрээнд Дорноговь аймгийн төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спортын цогцолбор

тэмцээнд Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцлоо.

Тус цогцолбор тэмцээнд гар бөмбөг, дартс, шатрын төрлүүдэд оролцсон бөгөөд “ШАТАР”-ын эмэгтэй төрөлд байгууллагын архивч Ц.Наранчимэг хурд хүч, оюун ухаанаа дайчлан өрсөлдөж ГУТГААР БАЙР эзэлж “Өргөмжлөл” хүрэл медалиар шагнууллаа.




Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлж буй шинэ технологи, инноваци, шилдэг туршлагаа иргэдэд танилцуулах үзэсгэлэнг Сайншандад 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Уг үзэсгэлэнд төр ба хувийн хэвшлийн 60 гаруй эрүүл мэндийн байгууллагууд оролцож, орон нутагт шинээр нэвтрүүлсэн шинэ технологи, шилдэг туршлага, оношилгоо эмчилгээний давуу тал, чадавхаа танилцуулсан арга хэмжээ болсон бөгөөд эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, зөвлөгөөнд хэлтсийн



албан хаагчид хамрагдав.

Төрийн албаны тасралтгүй хэвийн үйл ажиллагаа, хүний нөөцийн бүрдлийг хангах хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны улс орон даяар болж улсын хэмжээд Төрийн албаны ерөнхий шалгалт өгөхөөр 4106 иргэн бүртгүүлснээс Дорноговь аймагт 316 иргэн оролцохоор бүртгүүлсэн байна.

Шалгалт өгөхөөр бүртгүүлсэн оролцогч нарыг нэг ээлжид 23 оролцогчтойгоор 5 ээлжээр шалгалт авахаар бэлтгэлийг ханган шалгалтаа эхлүүлсэн. Шалгалтын явцыг кибер халдлага, хөндлөнгийн нөлөөлөлгүй явуулж, мэдээлэл сүлжээний аюулгүй байдлыг хангах ажлыг Дорноговь аймаг дахь Тагнуулын хэлтэс, шалгалтад бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг “Хур систем”-тэй тулгах, нягтлан шалгах ажлыг Улсын бүртгэлийн хэлтэс, Хэв журмыг сахиулахад Дорноговь аймгийн Цагдаагийн газар болон алба хаагч нар ажиллалаа.



“Танд ойрхон төрийн үйлчилгээ” аяны хүрээнд 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Айраг суманд, 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Дэлгэрэх суманд зохион байгуулсан. Энэ үеэр орон нутгийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж улсын бүртгэлийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээ, цаашид иргэдэд хүндрэлгүй, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцлоо.

2025 оны 5 дугаар сарын 12-ны өдөр "Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөн"-ий хүрээнд Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн ажлын албанаас сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хангах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор мэдээлэл өгсөн.



Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Сум дундын анхан шатны шүүх дэх Эвлэрүүлэн зуучлагч Б.Баттуяа, эвлэрүүлэн зуучлалын туслах ажилтан Ё.Мөнхсайхан нар 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн ажилтан, албан хаагчдад “Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа”-ны талаар мэдээлэл өгч, сургалт зохион байгууллаа. Сургалт, мэдээллийн үеэр ажилтнуудын сонирхсон асуултад хариулан эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд гаргах өргөдлийн загвар, танилцуулга, гарын авлага тарааж, төгсгөлд нь сургалтад оролцогсод шүүхийн үйлчилгээний талаар “Сэтгэл ханамж”-ийн судалгаанд хамрагдав.



Тус хэлтэс нь 2012 оноос орон нутгийн өмчийн Соёмбо цогцолборын Б1 давхарыг түрээслэн иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд 2022, 2023 онуудад үерийн ус, 2024 онд бохирын худаг халих, хоолой хагарах зэрэг хүндрэлтэй асуудал гарсан. Албан хаагчид болон иргэдэд стандартын шаардлага хангасан заал, танхимаар үйлчлэх хэрэгцээ шаардлага тулгараад байгаа бөгөөд Сайншанд сумын хэмжээнд ажлын байрны судалгаа явуулж “Саруул талын өргөө” ХХК-ийн удирдлагатай уулзаж барилгын зохион байгуулалттай танилцаж, ажлын байр түрээслэх талаар ярилцан, урьдчилан тохиролцсон бөгөөд энэ талаар аймгийн Засаг дарга болон ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга нартай уулзахад орон нутгийн удирдлагын зүгээс тодорхой дэмжлэг үзүүлэхээ мэдэгдсэн. Үүний дагуу УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст төсвийн тодотголд санал хүргүүлсэн.


Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон Иххэт суманд ажиллаж сумын удирдлагуудтай уулзаж хэлтсийн үйл ажиллагааг танилцуулан, шинээр хэрэгжүүлсэн болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцлоо.

Мөн сумын улсын бүртгэгчийн үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах зорилгоор 7 сумын улсын бүртгэгч болон бусад албан хаагчид хамтран оролцсон.



Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Хурдан төв болон Гэрэгэ систем хамтран Дорноговь аймгийн нийт 12 суманд төрийн үйлчилгээний киоск төхөөрөмж байршуулаад байна. Энэхүү төхөөрөмж нь иргэдэд Улсын бүртгэлтэй холбоотой 27 төрлийн үйлчилгээг түргэн шуурхай, өөрөө үйлчлэн авах боломжийг бүрдүүлж байгаа юм.

Энэхүү арга хэмжээ нь төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан бодит үр дүнтэй алхам болсон.



Замын-Үүд сумын Засаг дарга болон Тамгын газрын дарга, Багийн Засаг дарга нартай уулзалт зохион байгуулж Улсын бүртгэлийн хэлтсийн хэрэгжүүлсэн томоохон ажил, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар болон хамтран ажиллах чиглэлээр санал солилцлоо.

Албан хаагчдын ажлын ачаалал, ажиллах орчин, харилцаа хандлага, шаардлагатай тоног төхөөрмж зэрэг асуудлуудаар ярилцаж тодорхой шийдэлд хүрлээ.



Замын-Үүд суманд ажиллах үеэр Хилийн цэргийн 0108 дугаар ангийн шалган нэвтрүүлэх тасгийн удирдлага болон авто зам, төмөр замын боомтын удирдлагуудтай уулзалт зохион байгууллаа.

Уулзалтаар:

-Үндэсний энгийн гадаад паспортын иргэний овог нэрийн бичвэр (галиглах)-ийн зарим асуудал

-Монгол Хятад улсын хил орчимд зорчих нэг удаагийн болон олон удаагийн хавсралтын олголт, бүртгэлийн асуудлаар харилцан мэдээлэл солилцож нэгдсэн ойлголтод хүрлээ.

-Мөн хилийн шалган нэвтрүүлэх цахим гарцын үйл ажиллагаатай танилцаж Цахим гадаад паспортын хэрэглээ, ач холбогдлыг талаар иргэд, олон нийтэд сурталчилан таниулах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг сумдын бүртгэгч нарт чиглэл болголоо.



3

амы
н-
үүд
сум

анд ашиглалтад орж буй “Мандах-наран 2” түрээслээд өмчлөх орон сууцанд хамрагдах хүсэлтэй иргэдийн баримт материалыг журмын дагуу сонгон шалгаруулах ажлын хэсэг Замын-үүд суманд 10 өдөр ажилласан.

Замын-Үүд суманд түрээслээд өмчлөх зориулалтаар ашиглалтад орж байгаа “Мандах наран-2” хороололд хамрагдах зорилготой иргэдийн баримт материалыг журмын дагуу сонгон шалгаруулах аймгийн Орлогч дарга Г.Мартаар ахлуулсан ажлын хэсэгт УБХ-ийн дарга С.Энх-Эрдэнэ, хяналтын улсын байцаагч Э.Уранбилэг нар Замын-Үүд суманд ажилласан.Тодруулбал Түрээслээд өмчлөх орон сууцанд хамрагдах хүсэлтэй иргэд Замын-Үүд сумын 1-5 дугаар багийн ажлын албанд 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 17:00 цаг хүртэлх хугацаанд хүсэлт, материалыг битүүмжлэн хүлээлгэн өгсөн юм. Дээрх хугацаанд Замын-Үүд сумын 5 багийн 18,860 иргэн, 4,520 өрхөөс аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт урьдчилан өргөдөл гаргасан 1024 иргэн байсан. Ажлын хэсгээс олон нийтэд хүргэсэн мэдээллийн дагуу харъяа багийн ажлын албанд холбогдох журмын шаардлагын дагуу 790 иргэн материал бүрдүүлж хүлээлгэн өгсөн байна.



Голомт банкны Дорноговь аймаг дахь салбартай 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж “Шинэ төрсөн ээжүүдэд эрхийн бичиг” гардуулах ажлыг эхлүүлсэн.




ДОЛОО. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ

Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр С.Энх-Эрдэнэ томилогдон, ажил албан үүргээ хүлээн авсан бөгөөд албан хаагчид болон 14 сумдын улсын бүртгэгч нартай цахим уулзалт зохион байгуулсан.

Уулзалтаар сумдын улсын бүртгэлийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлуудтай танилцсан бөгөөд цаашид албан хаагчдын ажиллах нөхцөл байдлыг сайжруулах, нэгдсэн зохион байгуулалтаар ажиллах, мэргэжил арга зүйгээр бүрэн хангах, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, иргэд, олон нийтэд зөв боловсон үйлчилгээ үзүүлэх, ажил үйлчилгээгээ сурталчлах, цэгцтэй, бүрэн бүртгэлийг хэрэгжүүлэх, сахилга, дэг журмыг чанд мөрдөж ажиллах талаар чиглэл өгсөн.



Архивын өрөө танхимыг цэгцэлж, нэмэлт шүүгээ байрлуулах ажлыг зохион байгуулж Улсын бүртгэлийн ерөнхий газраас олгосон 4 нягтаршуулсан шүүгээг тус бүр байршуулсан.



Архивын өрөө нь зай талбай багатай учир нягтаршуулсан шүүгээг шаланд бэхэлж тогтоосон. Сумдын газар, эд хөрөнгийн хувийн хэргийг байршуулсан.



Эд хөрөнгийн архивт байсан Иргэний бүртгэлийн нас баралтын санг зөөж иргэний бүртгэлийн архивын өрөөний зүүн хананд байршуулсан.



Эд хөрөнгийн архивын өрөөний дотоод зохион байгуулалтыг сайжруулж 11,2 м2 талбайг сул чөлөөтэй болгосон.

7.1. Нэгдсэн сургалт зохион байгуулсан тухай

Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчдын дунд 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, цаашид анхаарах асуудлын талаарх сургалт, зөвлөгөөн 2025 оны 04 дүгээр сарын 09-өөс 11-ний өдрүүдэд зохион байгуулагдаж байна. Тус хэлтэс нь 2025 онд орон нутгийн иргэдэд улсын бүртгэлийн үйл ажиллагааг хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх зорилтыг дэвшүүлж “Манлайллыг үзүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх” жил болгон зарласан.

Тус арга хэмжээнд аймгийн Засаг даргын орлогч Г.Март оролцож аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, цаашид анхаарах асуудлын талаар үүрэг чиглэл өглөө. Энэ үеэр аймгийн Засаг даргын “Хүндэт жуух”, “Өргөмжлөл” болон Сайншанд сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын “Жуух” бичгээр нэр бүхий албан хаагчдыг тус тус шагнаж урамшууллаа.

Мөн албан хаагчдын ёс зүй, харилцаа болон авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд сургалт орлоо. Гадаад паспортын захиалгыг бүх сумдад авч эхлэхтэй холбогдуулан анхаарах асуудал болон иргэний гадаад паспортын зураг авахад анхаарах асуудлын талаар мэргэжлийн зурагчин зөвлөгөө өгч ажилласан.



Төрийн захиргааны албан хаагчидтай үйцэтгэлийн төлөвлөгөө баталсан тухай Улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэхүү баримт бичигт болон аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс сумдын улсын бүртгэгч нарын 2025 онд гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.




2025 оны 4 дүгээр сарын 16 нд хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ 14 сумын бүртгэгч нарт болон хэлтсийн албан хаагчдад шинэ бүтэц орон тооны талаар танхимын болон цахим сонсох ажиллагаа хийсэн.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Хуульчийн Про боно-2025” мөн “ТАНД ОЙРХОН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулан ажилласан. Энэхүү арга хэмжээнд төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай хамтран ажиллаж иргэдэд нэгдсэн, цогц үзүүлэн үйлчилгээг ажилсан.



Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан "Хамгийн чухал нь" зорилтот арга хэмжээний хэрэгжилтийг хангаж Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2025 оны 04 дүгээр сарын 09,10-нд сумын улсын бүртгэгч нарыг, 04 дүгээр сарын 26-нд хэлтсийн албан хаагчид, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг баг бүрэлдэхүүн тус аймагт ирж 2025 оны 05 дугаар сарын 22-нд эрүүл мэндийн эрт илрүүлэг, үзлэг оншилгоонд албан хаагчдыг бүрэн хамруулсан.



“Эрүүл мэнд эрхэм чухал” аяны хүрээнд хэлтсийн албан хаагчдыг эрүүл мэнд, үзлэг оншилгоонд хамруулсан ажлын үр дүнд үндэслэн “Хөдөлгөөн эрүүл мэнд” өглөөний алхалтын аянг эхлүүлсэн.



Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойд зориулсан спортын 4 төрөлт тэмцээнд Зүүн бүсийн аймгуудын баг тамирчид амжилттай оролцож Аймгийн УБХ-ийн архивч Ц.Наранчимэг дартсын төрөлд Алтан медаль, Ахлах бүртгэгч Б.Баттуяа эмэгтэй сагсны төрөлд багаараа алтан медаль тус тус хүртэж нийлбэр дүнгээр 4 дүгээр байрт шалгарсан.




“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тус байгууллага нь 950 хайлаас тод тарьсан. Үүнд: Дорноговь аймгийн Хамрын хийдийн 3 замын уулзвар Хилэнцэт хөшөөний дэргэд байрлах аялал жуулчлалын бүсийн ногоон

байгууламжид 50 хайлаас, Хамрын хийдэд байрлах “Энергийн элс” жуулчны баазад 100 хайлаас, иргэн С.Лхагвасүрэн мөн Д.Золбаяр нарын хашаанд хүлэмжийг тойруулан 800 ширхэг хайлаас мод тус тус тарьсан.



Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь “Говийн бүсийн зөвлөл”-ийн анхдугаар хуралдаан болохтой холбогдуулан байгууллагын гадна байрлах автомашины зогсоолын тэмдэглэгээг сэргээн будсан.



Соёмбо цогцолборын гадна Улсын бүртгэлийн хэлтсийн хаягийг хаягжуулсан.



Аймгийн хэмжээнд нийтийн эзэмшил, ногоон байгууламж, зам талбайн орчны бохирдолыг нарийвчилсан төлөвлөгөө байгууллагад хувиарласан ны өдөр цэвэрлэгээ хийж хэмжээнд хэлтсийн нийт хамрагдсан.



бууруулах цэвэрлэгээ хийх батлагдсаны дагуу тус 2,5 га талбайд сар бүрийн 25-гүйцэтгэлээ. Тус арга албан хаагчид бүрэн



Монгол Улсын
Засгийн газрын 2011
дүгээр тогтоолоор
батлагдсан
“Гамшгийн аюулын
тухай зарлан
мэдээллийн дохио
дамжуулах журам”,
Хэлтсийн “Гамшгийн
хамгаалах



ОНЫ

төлөвлөгөө”-ний дагуу ажилчид 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цагт бүх нийтийн зарлан мэдээллийн дохиогоор ажилласан.

Гамшгийн аюулын эхний дохиогоор ажилчид “Нуугд-Суу-Хүлээ” гэсэн зарчмыг баримтлан өрөө тасалгаандаа өөрийн аюулгүй байдлын хангах, өөрийгөө хамгаалах арга хэмжээ авч, ширээн доогуур орох, нуугдах арга хэмжээг авч хоёр дахь дохиогоор “Гүйхгүй, Түлхэхгүй, Эргэж буцахгүй, Хашгирахгүй” гэсэн зарчмыг баримтлан аврах гарц ашиглан барилгаас баруун гарын дүрмийг баримтлан гарч “Цугларах талбай”-д гарч бүртгэлд хамрагдаж, хүн нэг бүрийн үүргэвч, иж бүрдэлээ үзүүлж дадлага, сургуульд бүрэн хамрагдаж ажилласан.

Хэлтсийн даргын 2023 оны А/03 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалтыг баталж, мөн хэлтсийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж хянуулж батлуулсан.



Монгол
Улсын
Шадар
сайд,
аймгийн
Засаг




даргатай 2025 онд байгуулсан төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, гамшгаас хамгаалах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 15-17-ны хооронд зохион байгуулагдаж буй Гамшгаас хамгаалах команд штабын удирдах бүрэлдэхүүнийг гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох чиглэлээр чадавхижуулж танхимын сургалтанд Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч



Г.Батсайхан, улсын бүртгэгч Э.Ариунтуяа нар хамрагдсан бөгөөд сургуулийн өдрүүдэд аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажилласан.

Алба хаагчийн дүрэмт хувцсанд улсын бүртгэлийн лого бүхий, үндэсний монгол бичвэртэй зангиа хийлгэж “Говийн бүсийн зөвлөл”-ийн анхдугаар хуралдаанд ижилсэж оролцсон.



Ажилтан албан хаагчдын хүүхдийн судалгааг гарган 0-16 насны 48 хүүхдэд Эх үрсийн баярыг тохиолдуулан бэлэг гардуулсан.




Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь “Говийн бүсийн зөвлөл”-ийн анхдугаар хуралдааны бүртгэлийн үйл ажиллагааг бүрэн хариуцан зохион байгуулсан бөгөөд салбар зөвлөлийн хуралдаан, нэгдсэн хуралдаан, чөлөөт арга хэмжээнд оролцогчдын бүртгэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулан ажилласан.



Зөвлөгөөний бүртгэлийг зохион байгуулахдаа тус хэлтсээс нийт 10 албан хаагч ажилласан бөгөөд Хатанбулаг, Сайхандулаан, Айраг, Өргөн, Эрдэнэ сумдын улсын бүртгэгч нарыг татан оролцуулж зөөврийн компьютер 9, Иргэний үнэмлэхийн QR код уншигч 9, мандатын тэмдэглэгээ хийх багаж 9, хурууны хээ уншигч 5 төхөөрөмжийг тус тус ашиглан гүйцэтгэсэн.



Бүртгэлийг төрийн ороны нэвтрэлт танилтын систем (үндэсний ДАТА төв)-ийг ашиглан бүртгэлийг хөтөлсөн бөгөөд салбар зөвлөлийн хуралдаанд нийт 680 оролцогчийг, өдрийн нэгдсэн хуралдааны бүртгэлд 553 оролцогчдыг, оройн арга хэмжээнд нийт 152 бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэсэн байна.



Зөвлөгөөний хуралдааны танхимын үндсэн бүртгэлд 2 албан хаагчийг заалны зохион байгуулагчаар ажиллуулсан бөгөөд үндсэн хуралдааны тахимд орох 2 хаалганд тус бүр 4, нийт 8 бүртгэгчийг ажиллуулж хуралдаанд оролцогчдыг очер, дараалалгүй, түргэн шуурхай бүртгэсэн.



Мөн бүртгэлийн үйл ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулах бүх төрлийн арга хэмжээг тооцоолж үүдний зааланд чиглүүлэгч самбар 4, аймаг хуваарилсан самбар 4, имонголиа системээс иргэний үнэмлэхийн зураг гаргах зурган зааврыг 2 төрлөөр 6 байрлуулсан.





Мөн иргэний үнэмлэхгүй, имонголиа системд нэвтрэх боломжгүй хүмүүсийн иргэний бүртгэлийн 12 оронтой дугаарыг дотоод сүлжээнээс тухай бүр гарган түргэн шуурхай бүртгэлийн үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэсэн.

Хуралдаанд оролцогчдын бүртгэлд нэр ороогүй аймаг, сумд, иргэдийн зарим төлөөлөгчдийг “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн”-ийн албан хаагч нартай хамтран тухай бүр бүртгэл үүсгэж ажилласан бөгөөд энэ нь хуралд оролцогчдыг бухимдуулахгүй, удаан хүлээлгэхгүй оновчтой арга хэмжээ байсан бөгөөд асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэн ажилласан.

Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2012 оноос орон нутгийн өмчийн “Соёмбо цогцолбор”-ын Б1 давхарыг сарын 5 380 000 төгрөгөөр түрээслэн иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд Б1 давхарын өрөөнд үйл ажиллагаа явуулах нь үйлчилгээ авч буй иргэн болон албан хаагчдыг стандартад нийцсэн өрөө тасалгаагаар хангагдах эрхийг зөрчиж цаашлаад эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.



Мөн 2022, 2023 онуудад үерийн ус, 2024 онд бохирын худаг халих, хоолой хагарах зэрэг хүндрэл үүсч бохирын хурц үнэр үнэртэх, ариутгалын бодисоос хордох зэрэг хүндрэлтэй нөхцөл гарч байсан.



Албан хаагчдын 2025 оны 04 дүгээр сард эрүүл мэндийн үзлэг оншилгоо, эрт илрүүлэгт хамруулахад нийт албан хаагчдын 90% нь хүчил төрөгчийн дутагдалтай гэх дүгнэлт гарсан нь ажлын байрны орчиноос шууд хамааралтай байгаа тогтоосон.

Ажлын байрыг сайжруулах “Саруул талын өргөө” ХХК-ийн аймгийн төвд баригдаж байгаа 7 сард ашиглалтанд орох оффисын зориулалттай байрны явцтай танилаж удирдлагуудтай уулзалт хийж одоо баригдаж буй барилгын зохион байгуулалттай танилцаж, 2025 оны 12 дугаар сард 350 м2 талбайг түрээслэхээр тохиролцсон.

Мөн аймгийн Засаг дарга О.Батжаргал болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Н.Алдарбаяр нартай уулзалт зохион байгуулж харилцсан зөвшилцсөн бөгөөд ажлын хэсгийн дүгнэлт саналыг УБЕГ-т хүргүүлэн ажилласан

“Тэнгэрийн хутагт” фестиваль амжилттай болж өндөрлөлөө.Тус арга хэмжээнд Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн Боловсролын газар болон ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс хамтран тасалбар борлуулах, шалгах, бугуйвч зүүж нэвтрүүлэх хэсэгт 2 өдрийн турш ажилласан.



“Үндэсний өгөх өдөр” буюу 11 дүгээр сарын 01-ний өдрийн хүрээнд хэлтсийн албан хаагчид Сайншанд сумын 3 дугаар багийн ажлын албанд буцалтгүй тусламжийн барааг хүлээлгэн

Албан цаг ашиглалтыг мэнд, ажлын нэмэгдүүлэх хэлтсийн даргын дугаар сарын 31-



өгсөн.

хаагчдын ажлын сайжруулах, эрүүл бүтээмжийг зорилгоор тус 2025 оны 07 ний өдрийн А/15

дугаар тушаалаар ажиллах цагийг хуваарийг шинэчлэн өөрчлөлт орууллаа.

Иргэд, олон нийтэд бүртгэлийн үйлчилгээг авахад хялбар, ойлгомжтой байлгах үүднээс зурган гарын авлагын эмхэтгэл бэлтгэн байршуулсан.



НАЙМ. ШИНЭЭР САНААЧИЛАН ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Иргэд олон нийтэд үйлчлэх байнгын ажиллагаатай 7706-0101 дугаартай “onecall” үйлчилгээг нэвтрүүлсэн.





Аймгийн хэмжээнд нийт сумдын иргэд “Үндэсний энгийн гадаад паспорт”-ыг заавал аймгийн төвд ирж Улсын бүртгэлийн хэлтэст захиалдаг байсан бол 2025

оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн бүх сумдад гадаад паспортыг шууд захиалан хуулийн хугацаанд хүлээн авах боломжтой болгосон.



Нийт 14 сумын улсын бүртгэгч нарыг орон нутгийн иргэд, олон нийтэд улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилан таниулах, мэдлэг, мэдээлэл түгээх зорилгоор сумдын бүртгэгч тус бүрийг цахим хуудастай болгосон бөгөөд тус цахим хуудсыг хөтлөн олон нийтэд цахим мэдээ, мэдээллийг түгээх ажлыг эхлүүлсэн.



Аймгийн хэмжээнд “Мэдлэг түгээе”, “Мэдээлэл түгээе” аяныг эхлүүлэн үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хэлтсээс үзүүлж буй хугацаатай бүртгэлийн мэдээллийг иргэд, олон нийтэд мэдлэг олгох үүднээс “МЭДЛЭГ ТҮГЭЭЕ” аян, байгууллагаас гарч байгаа мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилан “МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭЕ” аяныг зохион байгуулан ажилласан.



“МЭДЛЭГ ТҮГЭЭЕ” АЯН

ГАДААД ПАСПОРТ ОЛГОХ ХУГАЦАА

- Насанд хүрсэн хүн **10 ЖИЛ**
- 16 хүртэлх насны хүүхдэд **5 ЖИЛ**

↓
хугацаатай олгоно

7706-0101 | dornogovi.burtgel.gov.mn

“МЭДЛЭГ ТҮГЭЭЕ” АЯН

180 ХОНОГООС ДЭЭШ ХУГАЦААГААР ОРШИН СУУХ БОЛ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛНЭ

ИРГЭН ТА

Одоогийн хаягнаас өөр хаягт шилжин оршин суух бол тухайн газрын **Улсын бүртгэлд 10 хоногийн** дотор шилжин ирсэнээ бүртгүүлээрэй.

dornogovi.burtgel.gov.mn | 7706-0101



Улсын бүртгэлийн хэлтэс нь орон нутгийн иргэддээ төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор нийт сумдад Үндэсний энгийн гадаад паспорт захиалах үйлчилгээг эхлүүлээд байгаа билээ. Энэ нь иргэд гадаад паспорт захиалахын тулд аймгийн төв рүү зорчих, үүнтэй холбогдсон зардал, цаг хугацааг хэмнэсэн бодитой арга хэмжээ болсон.

Энэхүү ажлын хүрээнд гадаад паспортыг иргэдэд эрсдэлгүй, аюулгүй, шуурхай хүргэх зорилгоор “Монгол шуудан”-гийн аймаг дахь салбартай гэрээ байгуулан ажиллаж эхэллээ. Тус байгууллага нь сумдад гадаад паспортыг эрсдэлгүй хүргэх асуудлыг бүрэн хариуцах бөгөөд “Дотоодын энгийн шуудан үйлчилгээ”-ний хамгийн бага тариф болох 4650 төгрөгөөр хүргэлтийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн.



Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын удирдлагууд хамтран тохиролцож төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, иргэн хуулийн этгээдэд хүндрэлгүй чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх, нэгдсэн ойлголтод хүрэх хамтарсан уулзалтыг зохион байгуулан ажилласан..

Тус уулзалтаар Үл хөдлөх эд хөрөнгөд гэрчилгээ олгох асуудал, Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн шилжилт хөдөлгөөний асуудал, Хаягийн асуудал зэргээр харилцан санал солилцож тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж хамтран ажиллахаар тохиролцсон.

Мөн аймгийн хэмжээнд иргэнд олгосон өмчлөлийн газрын мэдээллийн санг цэгцлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллийг холбож зөрчлийг арилгах ажлыг хамтран зохион байгуулахаар шийдвэрлэсэн.



Тус байгууллагын зүгээс улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүндрэлгүй, түргэн шуурхай хүргэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэ удаад бүртгэлийн үйлчилгээний хураамжийг Посс машинаар дамжуулан төлөх боломжийг нэмэгдүүлсэн.

Өөрөөр хэлбэл Гэрэгэ посс машинд бүртгэлтэй улсын бүртгэлийн үйлчилгээнд орон нутгийн онцлогоос хамаарсан 8 төрлийн төлбөрийн үйлчилгээг шинээр нэмэгдүүлж иргэд, олон нийтээс төлбөрийг тухай бүр авах боломжтой болсон.

Энэхүү үйлчилгээг хамгийн өндөр ачаалалтай Замын-Үүд сумаас эхлүүлж, тус сумын бүртгэгч нарт тус бүр посс машиныг гардуулан хэрэглээнд нэвтрүүлсэн.



ЕС. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 85 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХОИН БАЙГУУЛСАН АЖИЛ

Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 85 жилийн ойн хүрээнд Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хотод ажиллалаа.

Тус ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагаатай танилцаж, газрын дарга Д.Давааням болон иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, архивын газруудын удирдлага, ахлах мэргэжилтэнүүдээс сургалт, зөвлөгөө авч, албан хаагчдын мэдлэг мэдээлэл, чадавхыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулагдлаа. Уулзалтын үеэр Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням тус хэлтэст иж бүрэн компьютер болон принтер бэлэглэж тоног төхөөрмжийн дэмжлэг үзүүллээ.



үхбаа
тар
дүүрг



ийн Улсын бүртгэлийн хэлтсийн “Их тойруу” нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай танилцаж, ажлын туршлага солилцон, ажлын ачаалал болон нөхцөл байдлыг судалсан юм.



Арга хэмжээний үеэр төрийн ордонд зочлон, “Есөн хөлт цагаан туг”-нд хүндэтгэл үзүүлсэн бөгөөд тус арга хэмжээнд аймгийн бүх сумдын улсын бүртгэгч нар болон хэлтсийн нийт албан хаагчид бүрэн хамрагдсан.




Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 85 жилийн ойг угтан Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид “Улсын бүртгэлийн төгөл” нэртэй байгаль орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх санаачилгыг хэрэгжүүлсэн.

Дээрх цэцэгийн мандлын талбайг байгуулахад талбайг бэлтгэх, хагалах, зэрлэгийг түүх, сийрүүлэх хоносон усаар услах зэргээр бэлтгэн, эрүүл мэндийн цайны навч, цэцгийг тарьсан бөгөөд албан хаагчдын дархлааг нь дэмжихээр ажиллаж байна



Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойн арга хэмжээн хүрээнд “Мэргэжлээрээ бахархъя”, “Бүртгэгчийн нэг өдөр” богино хэмжээний контент бэлтгэн байгууллагын цахим хуудас болон УБЕГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.



Улсын бүртгэлийн 85 жилийн ойн хүрээнд Замын-Үүд сумын улсын бүртгэгч нараас санаачилан Тамгын газрын хамт олны дунд “ЧАНГА ШИВНЭЭ” хөгжөөнт тэмцээнийг зохион байгууллаа.



Улсын бүртгэлийн 85 жилийн ойн хүрээнд Айраг сумын улсын бүртгэгч Б.Уранчимэг нь 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн “Ажил, мэргэжлээ сурталчилах” 10 хоногийн аянг зарлаж аж ахуй нэгж байгууллагын албан хаагчдад зөвлөгөө, зөвлөмж, мэдээлэл өгч, өнөөдрийн байдлаар 56 албан хаагчид 63 гарын авлага тараасан байна.



Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойд зориулсан спортын 4 төрөлт тэмцээнд Зүүн бүсийн аймгуудын баг тамирчид амжилттай оролцож Аймгийн УБХ-ийн архивч Ц.Наранчимэг дартсын төрөлд Алтан медаль, Ахлах бүртгэгч Б.Баттуяа эмэгтэй сагсны төрөлд багаараа алтан медаль тус тус хүртэж нийлбэр дүнгээр 4-р байрт шалгарсан.



Тус арга хэмжээний үеэр байгууллагын нөөцөд бүртгэлтэй олон үйлдэлт скайнарын төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.



Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85 жилийн ойг угтсан ажлын хүрээнд сумын ЗДТГ-ын ёс зүйн дэд хороотой хамтран тамгын газрын ажилтан, алба хаагчдын дунд гар бөмбөг, буухиа тэмцээн зохион байгуулсан.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 85 жилийн ойг тохиолдуулан арилжааны банкуудын Дорноговь аймаг дахь салбаруудтай хамтран “Тоон гарын үсгээ хэрэглэж хэвшье” арга хэмжээг зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээний үеэр аймгийн Хаан банк, Голомт банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкуудын удирдлагууд болон ахлах менежерүүдтэй уулзалт зохион байгуулж тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа ашигладаг эсэх, иргэдэд тоон гарын үсгийг хэрхэн олгож байгаа талаар болон цаашид анхаарах асуудлаар санал солилцсон.



Тус хэлтсийн хамт олон “Нийгэмд тустай сайн үйлсийн аян-д нэгдэж аймгийн зорилтот бүлгийн 2 айлд дэмжлэг үзүүлэн тус бүр 1 тн нүүрс, мөн Монгол улсаа төлөөлөн “ӨСВӨРИЙН АЗИ ТИВ”-ийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан бяцхан охин Н.Анударьд 1.000.000 төгрөгийн хандив өгсөн.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ШАТРЫН СПОРТЫН ТАМИРЧИН НАНУДАРЬ

УЛС БҮСИЙН ТОМООХОН АМЖИЛТУУДААС ДУРЬДВАЛ

"Цахир хүү - 2024" шатрын улсын аварга 2-р байр
 "МИНИ-ШАТАР"-2024 өсвөрийн шатарчдын XIV тэмцээн 2-р байр
 "ДАЛААН ВЭРС-2024" өсвөрийн ринд улсын аваргын XVII тэмцээн 2-р байр
 2024 он УБ дахь "СҮҮ ХХК" дахь нэрэмжит өсвөрийн шатарчдын тэмцээн 2-р байр
 УОХ-ын дарга асан Д. Лундсаванцзэгийн нэрэмжит төвийн бус, говийн төсийн аймгуудын аварга шалгаруулах тэмцээн 1-р байр
 "Орон нутаг-2024" өсвөрийн шатарчдын УАШ тэмцээн 1-р байр
 "ЗҮҮН БҮС-2024" шатрын тэмцээн 2-р байр
 "ГОВИЙН БҮС-2024" шатрын тэмцээн 1-р байр
 "ГОВИЙН БҮС-2025" шатрын тэмцээн 1-р байр
 2025 он УБ дахь "СҮҮ ХХК" дахь нэрэмжит өсвөрийн шатарчдын тэмцээн 2-р байр
 "ДАЛААН ВЭРС-2025" өсвөрийн ринд улсын аваргын XVIII тэмцээн 1-р байр
 "ӨСВӨРИЙН УЛСЫН АВАРГА 2025" ШАТРЫН ТЭМЦЭЭНД 2-р байр
 "СҮРАГЧДЫН АЗИ ТИВИЙН" АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ БЛИЦ ТӨРӨЛД хувийн дүнгээр 4-р байр
 ВАГИЙН ДҮНГЭЭР АЛТАН МЕДАЛЬ ХҮРТСЭН.

НАНУДАРЬ нь 2025 оны Өсвөрийн улсын аваргид 2-р байр авалж "ТАЙЛАНД УЛСЫН БАНКТОЙ" хотод болох "ӨСВӨРИЙН АЗИ ТИВ"-н аварга шалгаруулах шатрын тэмцээнд МОНГОЛ улсаа төлөөлөн 2025 оны 11-р сарын 20-30 хооронд оролцох албан ёсны эрх авсан билээ. Иймд тус тэмцээнд зориулан хандивын аян эхлүүлж байна.

ХАНДИВЫН ДАНС: ГОЛОМТ БАНК IBAN 59001500 ДАНС: 2015110588
ДАНС ЭЗЭМШИГЧ: ШАТРЫН ВАГШ М.СОНИНБАЯР



АРАВ. ДҮГНЭЛТ.

Тус хэлтэс нь 2025 онд байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 11 арга хэмжээ, улсын бүртгэл хөтлөх 7 чиглэлийн арга хэмжээ, бүртгэлийн хяналтын чиглэлээр 5 арга хэмжээ, нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой 1 арга хэмжээ, бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр 20 арга хэмжээ, хэлтсээс зохион байгуулсан 28 арга хэмжээ, шинээр санаачилан хэрэгжүүлсэн 8 арга хэмжээ, Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойн хүрээнд 12 арга хэмжээ санаачилан хэрэгжүүлсэн бөгөөд нийт 92 арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна.

ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
 ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЭНХ-ЭРДЭНЭ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Н.ЦЭНДМАА